

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2020 оны 100 дугаар тушаалын  
7 дугаар хавсралт

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ГАЗРЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь 30,50, 70, 90
<b>НЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД</b>							
<b>Зорилт 1.1 Уялдаа: АЗДҮАМХ 3.1</b>		<b>Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллана.</b>					
1.1.1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллах;	-	Чанар, үр дүн, хэрэгжилтийн хувь, хугацаандаа тайлагнасан байдал	2021 оны хяналт, шинжилгээ, үнэлгээний дүн	Салбарт хамаарал бүхий зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж, холбогдох газруудад тайлагнасан байна.	-Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн акт, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын 2021 оны А/342 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу биелэлт, үр дүнг тооцож тогтоосон хугацаанд холбогдох газруудад хүргүүлээ. -Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт болон бусад бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг тухай бүр нэгтгэн гаргаж, ЗДТГ-ын ХБТХОХэлтэс болон холбогдох газруудад өгсөн.	100
1.1.2	Байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах талаарх	20.0	Мэдээлэл, сургалт	2021 онд нийт 60 эх бэлтгэл, сурталчилгааны	Сургалт, сурталчилгааны ажил хийгдсэнээр	-Байгаль орчны хууль, дүрэм, журам, стандарт, “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод бут тарих ажлыг иргэдэд	100

	иргэд олон нийтийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах;		сурталчилгааны тоогоор	постер, 23 удаагийн мэдээ, сурвалжлага, нэвтрүүлгүүдийг хийлгэж иргэд олон нийтэд хүргэсэн.	иргэдийн мэдлэг хандлага дээшилсэн байна.	<p>сурталчлах, мэдээ мэдээллийг олон нийтэд цаг алдалгүй хүргэх зорилгоор орон нутгийн “Соёмбо”, МҮОНР телевиз, ӨВ live.mn сайт, эх бэлтгэлийн “Оюу нана брэнд” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан, 78 эх бэлтгэл, сурталчилгааны постер, 32 удаагийн мэдээ, 4 сэдвийн сурвалжилга, 2 шторк, 5 шууд live нэвтрүүлгүүдийг хийлгэж аймгийн томоохон вэйб сайт болон байгууллагын пэйж хуудас, вэйб хуудсаар дамжуулан нийтэд сурталчиллаа.</p> <p>-Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах зорилтот жил"-ийн хүрээнд иргэдэд мод, бут тарих, чиглэлээр 11 удаагийн сургалт, 2 уулзалт, 1 зөвлөгөөн зохион байгуулж 1300 орчим иргэд хамрагдсан.</p> <p>Байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах талаарх иргэд олон нийтийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг 26 удаа зохион байгуулж, байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд Арвайхээр сумын ерөнхий боловсролын Мэргэд, I, II, IV, V дугаар сургуулийн 8-12 ангийн сурагчдад аймгийн нэн ховор, ховор амьтан ургамлын талаар танин мэдэхүйн сургалтыг зохион байгуулж 500 гаруй сурагчид хамрагдаж, “Цоохор ирвэс хамгаалах” дэлхийн өдрийн хүрээнд тус газраас сургалт танин мэдэхүйн хичээл, гарын авлага бэлтгэж Арвайхээр, Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Гучин-Ус, Уянга сумдын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, байгаль хамгаалагч нараар дамжуулан 8 сургууль, 1 цэцэрлэгийн 900 гаруй хүүхдүүдэд танин мэдэхүйн сургалт зохион байгууллаа. Түүнчлэн “Ан амьтад” гэрэл зургийн үзэсгэлэн, “Супер анги” шалгаруулах уралдаан, “Тарьц суулгацны үзэсгэлэн худалдаа”, “Тэрбум” мод</p>
--	---	--	------------------------	---	---	--

						<p>тарих үндэсний хөдөлгөөний нээлт зэрэг арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>-Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах зорилтот жилийн ажлыг сурталчлах, иргэд олон нийтийг идэвхжүүлэх зорилгоор улс, орон нутгийн авто зам дагуу болон гэрэлтүүлгийн шонд нийт 240 ширхэг мэдээллийн самбар байршуулж, 2100 орчим гарын авлага, материалыг хэвлэж иргэд олон нийтэд хүргэсэн бөгөөд аймгийн хэмжээнд шилдэг тохижилт, ногоон байгууламжтай сум, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, сургууль цэцэрлэг шалгаруулах 20.0 сая төгрөгийн шагналын сантай болзолт уралдааныг зарлан, дүгнэж ажиллалаа.</p>	
1.1.3	<p>“Иргэн бүр байгаль хамгаалагч” уриан дор байгаль орчныг хамгаалах, зөв дадал зуршил бий болгох зорилгоор сургалт, зөвлөгөөн, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, шаардлагатай сумдад идэвхтэн байгаль хамгаалагч улирлын чанартай ажиллуулах;</p>	-	<p>-Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах журмын хэрэгжилт хангагдсан байна.</p> <p>-Сургалт, зөвлөгөөн, нөлөөллийн ажлууд хийгдсэн байх</p>	-	<p>Шаардлагатай сумдад идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулж, урамшуулсан байна.</p>	<p>Иргэн бүр байгаль хамгаалагч уриан дор байгаль орчныг хамгаалах, зөв дадал зуршил бий болгох зорилгоор байгальд ээлтэй аялах, хог хаягдлыг бууруулах, тарьсан мод бутыг арчлах, ургуулах чиглэлээр цуврал постерууд хийж цахим орчинд байршуулж иргэд олон нийтэд хүргэсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр нийт 58 нөхөрлөл, мэргэжлийн байгууллага үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүнээс 52 ой хамгаалах нөхөрлөл, 18 ойн мэргэжлийн байгууллага, 2 усны мэргэжлийн байгууллага, 5 ан амьтан хамгаалах иргэдийн нөхөрлөл, 10 идэвхтэн байгаль хамгаалагч ажиллаж байна. 2022 онд Уянга суманд 1 идэвхтэн байгаль хамгаалагч нэмж томилсон бөгөөд Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу урамшууллын асуудал шийдэгдээгүй.</p> <p>-“Тэрбум” мод үндэсний хөдөлгөөн, зорилтот жилийн нээлтийн арга хэмжээний үеэр зохион байгуулсан аймгийн зөвлөгөөнд байгаль хамгаалах нөхөрлөл, аж ахуйн нэгж, идэвхтэн байгаль хамгаалагчдын төлөөллийг</p>	70

						оролцуулж, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан.	
1.1.4	Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор хуулийн байгууллагуудтай хамтран урьдчилан сэргийлэх ажил, хяналт шалгалт зохион байгуулах;	8.0	Хяналт шалгалтын тоо Илрүүлсэн зөрчлийн тоо Урьдчилан сэргийлэх арга хэмжээ;	Аймгийн хэмжээнд 2021 онд хүрээлэн буй орчны эсрэг 155 зөрчил илрүүлж, нийт 21 зөрчлийг хэрэгсэхгүй болгож 22 зөрчлийг харьяаллын дагуу бусад хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль хяналтын байгууллагуудтай хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулсан байна.	Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор аймгийн МХГ, Цагдаагийн газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. 2022 онд хүрээлэн буй орчныг хамгаалах журмын эсрэг 103 зөрчлийн мэдээлэл бүртгэгдэж, 74 зөрчилд 42.1 сая төгрөгийн торгууль оногдуулж, байгальд учирсан хохирлын 53.3 сая төгрөгийг нөхөн төлүүлж, 4 зөрчлийн мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, 23 зөрчлийг харьяаллын дагуу бусад хуулийн байгууллагад шилжүүллээ. Нийт 1.5 төгрөгийн эд зүйлийг улсын орлогод оруулсан бөгөөд түлээний мод 4.12 м/куб, хэрэглээний мод 320 ширхэг, амьтны гаралтай мах түүхий эд 108 ширхэг, хөрөө 1, сүх 1, буу 2, машин 1, мал 2, тэрэг 1, байгалийн ургамал, ойн дагалт баялаг 201.12 кг хурааж шийдвэрлэсэн байна. Мөн хүрээлэн буй орчныг хамгаалах журмын эсрэг эрүүгийн 12 хэрэгт байгальд учирсан 95.9 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр акт тогтоож, нийт байгальд учирсан 149.3 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр актаар тогтоолоо. Аймгийн ГХУСАЗСЗ-өөс 2022 онд хүрээлэн буй орныг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилсан сэргийлэх ажилд 9.3 сая төгрөг, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 8,0 сая төгрөг төсөвлөж, урьдчилан сэргийлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулан орон нутгийн түвшинд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт	100

						хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний илрүүлэлт, шийдвэрлэлтийг сайжруулах, холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлж ажилласны үр дүнд зөрчлийн тоо 2021 оноос 37 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	
1.1.5	ЗГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг хангах	-	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого-50 хувь Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого-85 хувь Ус рашаан ашигласны төлбөрийн орлого-35 хувь	2021 онд ойн нөөц ашигласны төлбөрийн орлого-417,618,8 мян.төг, ус, рашаан ашигласны төлбөр-305,730,1 мян.төг, ан амьтны нөөц ашигласны төлбөр-2,140,817.0 мянган төгрөгийг тус тус орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.	2022 оны орлогын төлөвлөгөөг биелүүлсэн байна.	-Аймгийн ИТХ-ын “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 07/08 дугаар тогтоолоор байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 562,0 сая төгрөг батлагдсан. Тус газраас 2022 онд уг зардлаар нийт 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр ЗГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу төлөвлөгөө боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, төлөвлөгөө, зардлын хуваарийг аймгийн Засаг даргын 2022 оны 01 сарын 31-ний өдрийн А/42 дугаар захирамжаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 2022 онд нийт 3,594,909,803 мянган төгрөг орсон бөгөөд нөөцөөр нь авч үзвэл: ан амьтны нөөц ашигласны төлбөр-2,451,194,824 мян.төг, ойн нөөц ашигласны төлбөр-713,977,544 мян.төг, сая, ус рашаан ашигласны төлбөр-429,737,435 мян.төг төвлөрсөн. -МУ-ын Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг танилцуулах, цувралт сургалтуудыг “Байгаль орчин, аялал жуулчлалын яам, НҮБХХ-ийн “Биологийн олон янз байдлын санхүүжилтийн санаачилга-БИОФИН-2 төсөлтэй хамтран 4 удаа, АТГ-аас 2 удаа, тус	100

						газраас 1 удаа танхимын хэлбэрээр тус тус зохион байгуулж, аймаг, сумдын Засаг дарга, ИТХурлын дарга, төлөөлөгчид, БОХУБайцаагч, Байгаль хамгаалагч, Татварын байцаагч, Газрын даамлууд, Төрийн сангийн мэргэжилтнүүд хамрагдлаа.	
1.1.6	Байгаль орчны статистик мэдээллийг <a href="https://www.eic.mn/box/">https://www.eic.mn/box/</a> программд тогтоосон хугацаанд бүртгэх ажлыг зохион байгуулах	-	Уул уурхай, ой, ус, ан амьтны нөөц ашиглалт, хог хаягдлын тайланг 9 үзүүлэлтээр	Уул уурхай, ой, ус, ан амьтны нөөц ашиглалт, хог хаягдлын тайланг 19 сумаар гаргасан.	Тайланг 19 сумаар нэгтгэж программд оруулсан байна.	-Байгаль орчны статистик мэдээ болох “БОХ” тайланг шинэчилсэн маягтын дагуу ойн сангийн өөрчлөлт, нөхөн сэргээлт, ашигт малтмалын нөөцийн өөрчлөлт, ус ашиглалт, хамгаалалт, агнуурын нөөц ашиглалт хамгаалалт, хог хаягдлын чиглэлээр гарган тогтоосон хугацаанд нэгтгэж байгаль орчны мэдээллийн сангийн программд <a href="http://www.eic.mn/box/login.php">http://www.eic.mn/box/login.php</a> хаягаар 19 сумын 126 тайланг бүртгэх ажлыг хийж гүйцэтгэлээ.	100
1.1.7	Салбарын сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг хариуцан зохион байгуулах, тайлагнах.	-	Гэрээний хэрэгжилт, үр дүнгээр	2021 оны гэрээний үүргийн биелэлт 90,6 хувьтай хэрэгжсэн.	Гэрээнд тусгагдсан зорилт арга хэмжээний биелэлтийг хэрэгжүүлж, тогтоосон хугацаанд холбогдох газруудад тайлагнасан байх;	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон мэргэжилтнүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заалт тус бүрээр тусгаж хэрэгжилт, үр дүнг хагас, бүтэн жилээр тооцож зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласнаар 2022 оны жилийн эцсийн үнэлгээгээр 91,1 хувьтай дүгнэгдсэн.	100
<b>Зорилт-1.2</b>		<b>Хүний нөөцийн талаарх бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх</b>					
1.2.1	Байгууллагын бүтэц, орон тоог оновчтой төлөвлөж, батлагдсан төсвийн хүрээнд ажиллах, хүний нөөцийн томилгоог холбогдох хууль журмын дагуу зохион байгуулах;	-	-Батлагдсан бүтэц, төсвийн хүрээнд ажиллах -Хууль бус томилгоо хийгдээгүй байх	2021 онд батлагдсан төсвийн дагуу ажиллаж, зайлшгүй шаардлагаар 1 түр томилгоо хийгдсэн.	-Сул орон тооны захиалгын салбар зөвлөлд уламжилж, нөхөх -Хүний нөөцийн томилгооны зөрчилгүй ажилласан байна.	-Тус газар нь байгууллагын даргын 2022 оны А/01 дүгээр тушаалаар албан тушаалын жагсаалт, цалингийн хэмжээг баталж тухайн жилд батлагдсан төсөв, бүтцийн хүрээнд үйл ажиллагаа явууллаа. 2022 онд Хархорин-2, Хужирт-1, Бат-Өлзий-2, Хайрхандулаан, Есөнзүйл, Богд сумдад тус тус 1, нийт 8 байгаль хамгаалагчийн сул ажлын байр гарч уг орон тоог нөхөх тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд уламжилж, 3 удаа зарлуулан Бат-Өлзий, Хайрхандулаан,	100

						Хужирт сумдын 3 сул орон тоог холбогдох хууль тогтоомжийн дагуу нөхөж, хууль бус томилгоо хийгдээгүй болно.	
1.2.2	Төрийн албан хаагчийн шагнал урамшууллыг ажлын гүйцэтгэл, үр дүнтэй уялдуулах олгох;	-	Ажлын гүйцэтгэл, шагналын болзол хангасан байдал	2021 онд төрийн болон салбарын шагналд 11 ажилтныг тодорхойлж, төрийн албан хаагчдын төсвийн шууд захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөг жилийн эцсээр үнэлж дүгнэн үр дүнгийн урамшуулал олгосон.	-Ажлын үр дүнг тооцох -төрийн болон салбарын шагналд албан хаагчдыг тодорхойлох;	-“Тэрбум” мод үндэсний хөдөлгөөний нээлтийн арга хэмжээний хүрээнд байгаль орчны салбарт үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчдыг салбарын шагналаар шагнуулахаар тодорхойлж, Байгаль орчны тэргүүний ажилтан цол тэмдэгээр 3 хүн, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны жуух бичгээр 3 хүн тус тус шагнагдсан. -Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр үнэлж дүгнэн үр дүнгийн урамшуулал олгох асуудлыг төсвийн боломжид тулгуурлан холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн. -2022 онд төрийн жинхэнэ албан хаагчдаас зэрэг дэв ахиулах болон шинээр олгох саналыг холбогдох материалын хамт Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд уламжилж, аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн б/10 дугаар захирамжаар 3 мэргэжилтэн, 3 байгаль хамгаалагчийн зэрэг дэвийг ахиулж, 2 байгаль хамгаалагчид шинээр зэрэг дэв олгосон.	100
1.2.3	Төрийн үйлчилгээний болон төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллах.	-	Ёс зүйн зөрчил гаргасан эсэх	Сүүлийн 3 жилд ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй.	Эхний хагас жилд: -Ёс зүйн тайлан мэдээг хүргүүлсэн байх; Жилийн эцэст: -Ёс зүйн зөрчил гараагүй байх;	-Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллагын дотоод журам, төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний талаар холбогдох зорилт, арга хэмжээг тусгаж, хэрэгжилтийг ханган ажилласнаар 2022 онд тус газрын төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой ирсэн гомдол, ажлын хариуцлага алдаж сахилгын арга хэмжээ тооцогдсон албан хаагч байхгүй байна. Ёс зүйн талаарх тайлан мэдээг Төрийн	100

						албаны зөвлөлийн салбар зөвлөлд тогтоосон хугацаанд тайлагнасан.	
<b>Зорилт 1.3</b> <b>Уялдаа: АЗДҮАМХ</b> <b>4.1.3.1-3.4</b>		<b>Ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, ойг нөхөн сэргээх, хамгаалах, зүй зохистой ашиглах талаар</b>					
1.3.1	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах;	-	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулах арга хэмжээний стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан байна.	2021 онд аймгийн хэмжээнд 40,5 мянган мод бут тарьсан.	Аймгийн хэмжээнд 200,0 мянган ширхэг мод, бут	"Тэрбум" мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022-2030 оны хугацаанд тарих модны тооцоолол, стратеги, төлөвлөгөөний урьдчилсан төсөөллийг боловсруулж БОАЖЯам, Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн. Улсын хэмжээний стратеги төлөвлөгөө батлагдсаны дараа аймгийн нарийвчилсан төлөвлөгөөг 2023 онд хийгдэх аймгийн Ойн менежментийн төлөвлөгөөтэй хамтатган шинэчлэн боловсруулж батлуулахаар төлөвлөж байна. Аймгийн хэмжээнд "Тэрбум" мод үндэсний хөдөлгөөн, бүх нийтээр мод тарих хавар, намрын өдрүүдийн хүрээнд нийт 320.0 мянган ширхэг мод, бут тарьж, нийт тарьсан модны 36.0 мянган ширхэгийг айл өрх, 70.0 мянга орчим ширхэгийг албан байгууллага, аж ахуйн нэгжүүд, 140.0 мянган ширхэгийг төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид, 74.0 мянган ширхэгийг ойжуулалт, хамгаалалтын ойн зурваст тарьж мод бут тарих ажилд нийт 492 аж ахуйн нэгж, байгууллага, 16428 иргэн оролцож, тарьсан модны амьдралтын хувь дундажаар 80 хувьтай ургасан.	100
1.3.2	Мод, сөөгийн үрийн нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;	-	Аймагт шаардлагатай мод, сөөгийн үрийн нөөц бүрдүүлсэн байх;	2021 онд навчит модны үр-35 кг бэлтгэсэн	-Шилмүүст модны үр-200 кг -Навчит модны үр-400 кг	Өвөрхангай аймгийн мод үржүүлгийн үйл ажиллагаа явуулдаг ойн мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж иргэд шинэсний үр-180 кг, хайлаас, шар хуайсны үр 300 кг, загийн үр 3 кг, бусад мод сөөгний үр 40 кг түүж бэлтгэсэн байна.	100



1.3.3	Жилд 1.0-1.5 сая ширхэг тарьц ургуулах мод үржүүлгийн газар 3-аас доошгүйг шинээр байгуулах ажлыг эхлүүлэх;	200.0	Тарьц суулгацын нөөц бүрдүүлэх, нэмэгдүүлэх зорилгоор МҮГазрын хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөх, шинээр байгуулах	2021 онд аймгийн хэмжээнд нийт 8 га талбай бүхий 10 мод үржүүлгийн газар байдаг.	2021 онд 3-аас доошгүй МҮГазар байгуулах	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах зорилтот жилийн хүрээнд орон нутагт мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор хангай, тал хээр, говиор бүсчилэн “Арвайхээр цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ, “Сум дундын Ойн анги”, “Өгөөмөр шунхлай” ХХК, “Бат-цэцэрлэгжилт” ХХК, “Өв-эхлэл өнгө” ХХК, “Их говийн төгөл” ХХК зэрэг 6 аж ахуйн нэгж, байгууллагад 216,0 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс олголоо.Тус аймагт 2021 онд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн мод үржүүлгийн 10 газарт 15 нэр төрлийн нийт 327.9 мянган тарьц, суулгац ургуулж байсан бол, 2022 онд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх 11 аж ахуйн нэгж, иргэн нэмэгдэж, мод үржүүлгийн 21 газарт 18 нэр төрлийн 2.0 сая орчим тарьц суулгац ургуулаад байна.	100
1.3.4	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд ойн зурвас, ойн төгөл байгуулах зорилгоор 300 га талбайг тусгаж, шийдвэрлэх;	-	-Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан эсэх	-	300 га талбай	-Газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөнд 13 суманд 458,7 га газрыг мод тарих, ногоон байгууламж байгуулах, мод үржүүлгийн газар байгуулах иргэн аж ахуйн нэгжид олгохоор тусгаж 100 орчим га талбайг мод үржүүлэг, ногоон байгууламж байгуулах зориулалтаар олгосон байна.	100
1.3.5	Мод, сөөгийн тарьц, суулгацын нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;	-	Мод, сөөгийн тарьц, суулгацын нөөц бүрдүүлсэн байх	327,9 мянган ширхэг	-Шилмүүст модны тарьц, суулгац 0.150 сая.ш -Навчит модны тарьц, суулгац-0.3 сая.ш	Өвөрхангай аймгийн хэмжээнд 2021 онд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн 10 мод үржүүлгийн газарт 15 нэр төрлийн нийт 327.9 мянган тарьц суулгац ургуулж байсан бол 2022 онд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, иргэдийн тоо 11-ээр нэмэгдэж 21 мод үржүүлгийн газарт 18 нэр төрлийн 2 сая орчим тарьц суулгац ургуулсан байна. Нийт ургуулсан тарьц	100

						суулгацын дотор 2 настайгаас дээш буюу 2023 онд ойжуулалт цэцэрлэгжүүлэлтэд шилжүүлэх тарьц суулгац 340.0 мянга орчим байгаа бол 2024 оноос эхлэн жил тутам 1200.0 мянгаас дээш тооны тарьц суулгацыг нийлүүлэх боломжтой болсон.	
1.3.6	-0.6 саяаас доошгүй мод тарих ажлыг зохион байгуулах;	-	Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд тарих модны тоо	2021 онд 40594 ш мод тарьсан	600,000-аас доошгүй тарих мод	Аймгийн хэмжээнд “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөн, бүх нийтээр мод тарих хавар, намрын өдрүүдийн хүрээнд нийт 320.0 мянган ширхэг мод, бут тарьж нийт тарьсан модны 36.0 мянган ширхэгийг айл өрх, 70.0 мянга орчим ширхэгийг албан байгууллага, аж ахуйн нэгжүүд, 140.0 мянган ширхэгийг төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид, 74.0 мянган ширхэгийг ойжуулалт, хамгаалалтын ойн зурваст тарьж мод бут тарих ажилд нийт 492 аж ахуйн нэгж, байгууллага, 16428 иргэн оролцож, тарьсан модны амьдралтын хувь дундажаар 80 хувьтай.	70
1.3.7	Ойжуулалт, ойн зурвас байгуулах ажил гүйцэтгэх;	Улс, орон нутаг	Өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийгдсэн эсэх;	2021 онд 24 га талбайд өөрийн хөрөнгөөр, орон нутгийн төсвөөр 20 га ойжуулалтын ажил хийгдсэн.	25 га	2022 онд Бат-Өлзий сумын ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгж, нөхөрлөлүүд Ойн ангиас шийдвэрлэсний дагуу өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх ойжуулалтын ажлыг дүйцүүлж, сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайд 9000 ширхэг модыг тарьсан бөгөөд шинэсний тарьцаар гүйцэтгэх ойжуулалтын ажил 10 га талбайд хийгдсэн. Хархорин суманд газар тариалан эрхэлдэг 16 аж ахуйн нэгж 10 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулж, 16.0 мянга, Төгрөг сумын Мазарт 6 га талбайг хашиж агро ойжуулалтаар 1200 ширхэг мод тус тус тарьсан. Улсын чанартай авто зам дагуу мод тарих ажлыг эхлүүлж Арвайхээр суманд 2500 м, Хужирт суманд 800 м, Хархорин суманд 900 м, нийт 4.2 км урт ойн зурвас байгууллаа. “ӨВ-А33А” ТӨХКомпани Бүрд сумын Шариланд 1 га талбайд “Алтан шар зам” төгөл байгуулж 1000	100

						ширхэг мод тарьсан. Улсын төсвийн 90,0 сая төгрөгийн санхүүжилтээр газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд Баруунбаян-Улаан суманд 8 га хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг “Их сумт хайрхан” ХХКомпани гүйцэтгэлээ.	
1.3.8	Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх устгал тэмцлийн ажил гүйцэтгэх;	86.0	Үүргийн шүршигч багаж ашиглан химийн аргаар тэмцэх ажлыг гүйцэтгэнэ.	2021 онд 4700 га талбайд хортон устгалын ажил хийгдсэн.	2000 га-д	Тус аймагт ойн хөнөөлт шавжийн хөнөөлийн голомт ой бүхий 5 сумын 30.0 мянга орчим га талбайг хамарсан. Шинэсний шилмүүс хуйлагч, яacobсоны төөлүүрч эрвээхэйн хөнөөлийн голомт илэрсэн Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Хужирт, Хархорин сумдын ойн сан бүхий газруудаар ойн хөнөөлт шавжтай үүргийн шүршигч багаж ашиглан тэмцэх ажлыг 2022 оны 06 сарын 18-28-ныг хүртэлх хугацаанд хийлээ. Уг ажлын гүйцэтгэгчээр “Гранд Форест” ХХКомпани шалгарч Бат-Өлзий суманд 1000 га, Хужирт суманд 500 га, Зүүнбаян-Улаан суманд 500 га, Хархорин суманд 500 га талбайд гүйцэтгэж уг арга хэмжээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 86,0 сая төгрөгийн санхүүжилт олголоо. Мөн Бат-Өлзий, Хужирт сум, сум дундын Ойн ангиас нэмэлт хөрөнгө гаргаж 1300 га талбайд устгалын ажил хийснээр аймгийн хэмжээгээр нийт 3800 га талбайд ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажил хийгдсэн.	100
1.3.9	Мод тарих газрын хамгаалалтын хайс, хашаа барих;	75.6	Хамгаалалтын хайс, хашааг хямд өртөг зардлаар шийдвэрлэсэн байх	-	Хашааны материал нийлүүлэгдсэн байна.	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар гүйцэтгэх мод тарих газрын хамгаалалтын хашаа барих ажлын гүйцэтгэгчээр “Их өшгөр” ХХК шалгарч, Арвайхээр сумын нийтийн эзэмшлийн талбай, Цэргийн анги, УБ-Арвайхээрийн авто замын дагуу мод тарих 4 хэсэг талбайд 6300 м урт хамгаалалтын хашаа барьсан. Уг ажилд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 75.6 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж хашааны шонг хаягдал	100

						хуванцараар ашиглаж хийсэн. Аймгийн хэмжээгээр мод тарьсан газрыг услах зориулалтаар нийт 19 худаг, 2200 метр усалгааны систем, 27000 уртааш метр хайс хашаа хийгдсэн.	
1.3.10	“Тэрбум” мод хөдөлгөөний хүрээнд төв суурин газрын нийтийн эзэмшлийн талбайд тарих модны тарьц, суулгац худалдан авч сумдад нийлүүлэх;	60.0	Стандартын шаардлага хангасан тарьц суулгац нийлүүлсэн байна.	2021 онд 3500 ш	10000 ш	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022 онд Өвөрхангай аймгийн төв суурин газрын нийтийн эзэмшлийн талбайд тарих модны тарьц суулгац, нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр “Арвайхээр-Цэцэрлэгжилт” ОНӨААТҮГазар шалгарч нийт 3 нэр төрлийн 17110 ширхэг модны тарьц суулгац худалдан авч 17 суманд нийлүүллээ. Уг ажилд 60,0 сая төгрөгийн санхүүжилт олголоо. Мөн аймгийн зорилтот жилийн үйл ажиллагааны зардлаар 13000 ш, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас дэмжлэг авч мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн чадавхыг бэхжүүлэх, тарьц суулгац нийлүүлэх ажил гүйцэтгэсэн 6 аж ахуйн нэгж 21650 ш, сумдууд зорилтот жилийн хүрээнд орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвөөс 50 гаруй мянган ширхэг, хувийн хэвшил, иргэдийн хандив тусламжаар 30 мянга орчим тарьц суулгац нийлүүлж төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид тарьжээ.	100
1.3.11	Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж тарьц, суулгацын нөөцийг нэмэгдүүлэх;	16.0	Тарьц, суулгацын нөөцийг нэмэгдүүлэх	2021 онд 9,0 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн.	150000-аас доошгүй	2022 онд Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газрыг 3 га талбайгаар өргөтгөж хөрс боловсруулах, тарьц суулгац ургуулах ажил төлөвлөгөөний дагуу бүрэн хийгдлээ. Мод үржүүлгийн газарт шаардлагатай үр, мөчир бэлтгэх, бордоо, ариутгалын бодис, хүлэмж, усалтын систем авах, гэрээт ажилтан ажиллуулах зэрэг ажилд дэмжлэг үзүүлж БОХНСАХэмжээний зардлаас 16,0 сая төгрөг, аймгийн зорилтот жилийн үйл ажиллагааны зардлаас 30.0 сая төгрөгийн санхүүжилт тус тус олголоо. 2022 онд Ойн	100

						ангийн мод үржүүлгийн газарт, шинэсний тарьц 160 мянга, навчит модны тарьц, суулгац 287 мянган ширхэг, нийт 447 мянган ширхэг тарьц суулгац ургуулсан.	
1.3.12	Мод тарьж ургуулах “1000 сургагч багш” бэлтгэх сургалтад оролцох орон нутгийн оролцогчдын судалгааг гаргах, бэлтгэгдсэн сургагч багш нарыг сургалт явуулах нөхцөл, боломжоор хангах;	-	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэхэд хамтран ажиллах сургагч багш нар бэлтгэгдсэн байна.	-	Сум бүрт 3-аас доошгүй сургагч багш бэлтгэнэ.	-БОАЖЯам, МУИСургуулиас “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 1000 сургагч багш бэлтгэх цахим сургалтыг 2022 оны 05 сарын 13-18-ны хооронд зохион байгуулж, уг сургалтад Өвөрхангай аймгаас 30 хүн хамрагдсан. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, зорилтот жилийн нээлт болон аймгийн зөвлөгөөнийг 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж уг зөвлөгөөнд Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамны төлөөлөл, Хөдөө аж ахуйн их сургуулийн доктор, багш, судлаач, аймгийн хэлтэс, агентлагийн дарга нар сумдын удирдлагууд, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүд, байгаль хамгаалагчид, “Жимс жимсгэнийн холбоо”, ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөл, мод бут тарьдаг иргэдийн төлөөлөл нийт 250 хүн оролцлоо. Энэ үеэр мод бут тарих, агро ойжуулалтын хийх арга зүйн сургалт зохион байгууллаа. “БНХАУ-ын цөлжилтийг сайруулах арга туршлага” сэдэвт сургалт, Геоэкологийн хүрээлэнгээс зохион байгуулсан “Мод бут тарих, мод үржүүлгийн газар байгуулах” сэдэвт цахим сургалтуудад сумдын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүд, Байгаль хамгаалагчид, Сум дундын Ойн ангийн ажилтуудыг хамруулж чадавхжууллаа.	100
1.3.13	Баруунбаян-Улаан сумын цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт	УТ 90.0	Гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах	-	8 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулсан байна.	Улсын төсвийн 90,0 сая төгрөгийн санхүүжилтээр газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд Баруунбаян-Улаан суманд 8 га хамгаалалтын ойн зурвас	100

	хамгаалалтын ойн зурвас байгуулах.					байгуулах ажлыг “Их сумт хайрхан” ХХКомпани гүйцэтгэлээ. Ойн зурваст хайлаас, загийн бортоготой тарьц 6800 ширхэгийг тарьсан нь намрын тооллогоор 85 хувийн амьдралттай тоологдлоо. БОАЖЯам болон аймгийн Засаг даргаас томилогдсон ажлын хэсэг газар дээр нь очиж ажлын гүйцэтгэлийг актаар хүлээн авсан.	
<b>Зорилт 1.4</b> <b>Уялдаа: АЗДҮАМХ 4.1.3.1-3.4</b>		<b>Усны нөөцийн ашиглалт, хамгаалалт</b>					
1.4.1	Булаг шанд, рашааны эхийг хашиж хамгаалах;	14.0	20-иос доошгүй булгийн эхийг хашиж хамгаална.	2021 онд 15 булаг шанд, рашааны эхийг хашиж хамгаалсан	Шаардлагатай газруудад булаг шанд, рашааны эхийг хашиж хамгаалсан байна.	2022 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал болон орон нутгийн төсвөөр Баруунбаян-Улаан, Баянгол, Нарийнтээл, Өлзийт, Баян-Өндөр, Хужирт, Хархорин, Уянга, Бат-Өлзий сумдад нийт 33 булаг шанд, рашааны эхийг хашиж хамгаалан, нутгийн иргэдтэй хариуцан хамгаалах гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн.	100
1.4.2	Рашааны тоо бүртгэлийг зохион байгуулж, орон нутгийн чанартай, бүрэн судлагдаагүй рашааны чанар найрлагыг тодорхойлох судалгаа хийлгэнэ;	15.0	Рашааны физик-химийн найрлагыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгосон байх	Хужирт рашааны нөөцийг тогтоосон.	Орон нутгийн чанартай, бүрэн судлагдаагүй рашааны чанар найрлагыг тодорхойлох судалгаа хийлгэж, тооллого зохион байгуулна.	Орон нутгийн чанартай, бүрэн судлагдаагүй Бат-Өлзий сумын Хуст, Ар хятруун, Могойт, Үүртийн тохой, Баруунбаян-Улаан сумын Хүрэн хад, Уянга сумын Өвөр хятруун, Тарагт сумын Хүрэмт, Эмт, Арвайхээр сумын Дэлгэрэх, Бурхи зэрэг рашаануудын физик, химийн найрлагыг тодорхойлох судалгааны ажлыг 2022 оны 06-09 сарын хугацаанд МУ-ын усны чанарын зөвлөх инженер, гидрохимич Ч.Жавзан доктороор ахлуулсан судалгааны багаар гүйцэтгүүлсэн. Хээрийн судалгааны ажлаар холбогдох аргачлалын дагуу усны сорьц авч, ерөнхий химийн болон бохирдлын шинжилгээг Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн Усны шинжилгээний лабораторид, бичил амь судлалын шинжилгээг газар дээр нь болон сорьц авч биологийн хүрээлэнгийн микробын нийлэгжлийн лабораторид, бичил элементийн дэлгэрэнгүй шинжилгээг “SGS IMME Mongolia”	100

						ХХК-ний лабораторид ICP80T маркийн багажаар тус тус тодорхойлуулж, судалгааны тайланг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, хүлээн авсан.	
1.4.3	Уянга, Зүүнбаян-Улаан, Тарагт сумын усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоож, тэмдэгжүүлэх;	2.0	Уянга, Зүүнбаян-Улаан, Тарагт сумын усны сан бүхий газарт хамгаалалтын бүсийг хуулийн хүрээнд тогтоох	Хужирт рашаан, Арвайхээр, Хархорин сумын ус хангамжийн эх үүсвэрт координатжуулж хамгаалалтын бүс тогтоосон.	Уянга, Зүүнбаян-Улаан, Тарагт сум	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны А/36 дугаар тогтоолоор Арвайхээр сумын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт ба хязгаарлалтын бүсийг 9.5 га газарт тогтоон, дэглэмийг мөрдүүлж, Арвайхээр сумын төвлөрсөн ус хангамжийн эрүүл ахуйн хязгаарлалтын бүсэд орсон айлыг нүүлгэн шилжүүлж, "Цуврайн гол" ХХК-иар ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэсэн.	70
1.4.4	Шаардлагатай газарт хөв цөөрөм байгуулах зураг төсөв хийлгэх;	12.0	Мэргэжлийн байгууллагаар зураг төсөв хийлгэсэн байх	Дэлгэрэхийн дээд эхэнд хөв байгуулсан.	Шаардлагатай газарт хөв цөөрөм байгуулах зураг төсөв хийгдсэн байна.	Нарийнтээл сумын "Их булаг" хэмээх газарт хөв цөөрөм байгуулах зураг төсөл боловсруулах ажлыг усны мэргэжлийн байгууллага болох "Гидрофонтан" ХХКомпаниар гүйцэтгүүлж, улсын зкспертизээр баталгаажсан тайлан, зураг төсвийг хүлээн авсан.	100
1.4.5	"Тэрбум" мод тарих хүрээнд мод тарих бүсийн ус хангамжийг шийдвэрлэх төлөвлөгөө боловсруулж, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх.	-	Мод тарих газрын усалгааны эх үүсвэрийг шийдвэрлэсэн эсэх	Урьд жилүүдэд таригдсан мод бутны усалгааны эх үүсвэрүүдийг тухай бүр шийдвэрлэсэн.	Бүх сумд	"Тэрбум" мод үндэсний хөдөлгөөн, зорилтот жилийн хүрээнд мод тарих бүсийн ус хангамжийг шийдвэрлэх хүрээнд "Хөдөө аж ахуйг дэмжих сан"-гийн хөнгөлөлтөд 2 аж ахуйн нэгж хамрагдаж, хямд өртөгтэй дуслын болон намираа усалгааны систем, усны нөөцийн сав, бусад тоног төхөөрөмж, Арвайхээр сумын "Их монгол" цэцэрлэгт хүрээлэнд 10 га-гийн дуслын усалгааны систем зэргийг тухайн сангаас хөнгөлөлттэй нөхцлөөр худалдан авсан. Аймгийн хэмжээгээр мод тарьсан газрын усалгаанд зориулж гүн өрмийн 16 худаг, гар худаг 3-г шинээр гаргаж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл авахад нийт 514.1 сая төгрөг, ногоон байгууламжийн хашаа барих, мод тарихад 947.6 сая төгрөгийг төр, хувийн хэвшлээс зарцуулсан байна.	100

Зорилт 1.5 Уялдаа: АЗДҮАМХ 4.1.2.1-2.4		Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийг хамгаалах талаар:					
1.5.1	“Баянтээг түлш” ОНӨХХК-ний тоног төхөөрөмжийг өргөтгөж, сайжруулсан шахмал түлшээр Арвайхээр сумын гэр хорооллын айл өрхийг хангана.	-	Арвайхээр сумын гэр хорооллын айл өрхүүдийг сайжруулсан шахмал түлшээр хангаж агаарын бохирдлыг бууруулах	Арвайхээр сумын Эмтийн 2 дугаар багийн айл өрхүүдийг сайжруулсан шахмал түлшээр хангаж хэрэглээнд нэвтрүүлж эхэлсэн.	Арвайхээр сумын гэр хорооллын айл өрхүүдийг сайжруулсан шахмал түлшээр хангасан байна.	“Баянтээг түлш” ОНӨХХК-нь 2022 онд 380 тонн шахмал түлш үйлдвэрлэж, Арвайхээр сумын Эмтийн 2-р багийн гэр хорооллын 500 айл өрхүүдийг шахмал түлшээр ханган ажиллаж байна. Тус үйлдвэрт Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос 2,1 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлэх гэрээг байгуулж гэрээний дагуу үйлдвэрийн өргөтгөл, олон үйлдэлт зуух, хатаалгын төхөөрөмжийн угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Блейз тек” ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгэл 40 хувь, 300 тонн шахмал түлш нөөцлөх агуулахын барилгын ажлын гүйцэтгэгчээр “Шоо констракшн” ХХК шалгарч ажлын гүйцэтгэл 70 хувь хийгдэж тус тус гүйцэтгэлээр санхүүжилтээ аваад байна. Мөн тухайн санхүүжилтээр 1000 ширхэг мэдээлэл дамжуулах чиптэй угаар мэдрэгч төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр “Интеллигент технологи” ХХК-тай гэрээ байгуулж гэр хорооллын айл өрхүүдэд суурилуулах ажил хийгдэж байна.	70
1.5.2	Нутаг дэвсгэрийн хэмжээнд аюултай хог хаягдлын тооллогыг зохион байгуулж, аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалж, эрх бүхий мэргэжлийн байгууллагаар	-	Нутаг дэвсгэрийн хэмжээнд аюултай хог хаягдлын тооллогыг зохион байгууна.	Нэр хаяг тодорхойгүй, ашиглалтын хугацаа дууссан химийн бодисын тооллого 2014 онд хийгдсэн.	Аймгийн хэмжээнд аюултай хог хаягдлын судалгааг гарган нэгтгэж, мэргэжлийн байгууллагаар устгуулах ажлыг зохион байгуулах	-2022 онд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Ерөнхий боловсролын 24 сургуулийн химийн кабинет, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болон Хужирт сумын “Жем Хужирт” ХХК-ийн лабораториудад хадгалагдаж байсан ашигладаггүй, хугацаа дууссан шингэн 407,5 л, хатуу болон нунтаг 462,3 кг бодис, 30 гаруй тонн газар тариалангийн хортонтой тэмцэх химийн болон бактерийн бордоо зэрэг 1584 нэр төрлийн химийн аюултай бодисуудыг	100



	устгуулах ажлыг зохион байгуулах;					мэргэжлийн байгууллага болох "Түмэн эгшиг" ХХК-тай гэрээ байгуулан Улаанбаатар хот руу тээвэрлүүлж, устгуулах ажлыг 19 сумын ЗДТГ, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Уг арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 19,800,0 мянган төгрөг зарцуулсан.	
1.5.4	Хог хаягдлын менежментийг сайжруулах, байгууллага, иргэн аж ахуйн нэгжийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх замаар хог хаягдлыг бууруулж, эх үүсвэр дээр нь ангилж, хөдөө нутаг, гол усны хогийг цэвэрлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	-	Аймгийн хэмжээнд бүх нийтийн их цэвэрлэгээг 4-оос доошгүй удаа зохион байгуулсан байх	2021 онд бүх нийтийн их цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулж, нийт 660 тн хог хаягдлыг цэвэрлэж төвлөрсөн хогийн цэгт нийлүүлсэн.	Аймгийн хэмжээнд улирал бүр "Бүх нийтийн цэвэрлэгээ"-ний ажил зохион байгуулж, хэвшүүлнэ.	-Аймгийн хэмжээнд улирал бүр бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж 2022 онд нийт 4 удаагийн их цэвэрлэгээгээр давхардсан тоогоор 36659 иргэн оролцуулж 6135,7 тонн хог хаягдлыг цэвэрлэж төвлөрсөн хогийн цэгт хүргэх ажлыг зохион байгуулсан. -Малын сэг зэмийн устгал гол ус, булаг шанд, овоо даваа, бэлчээр дагуух хог хаягдлыг цэвэрлэх чиглэлээр 55 аян зохион байгуулж, нийт 497,5 тонн хог хаягдлыг цэвэрлэж сумдын төвлөрсөн хогийн цэгт хүргэж ажилласан байна. -Аймгийн хэмжээнд бүх нийтийн хог цэвэрлэгээ болон төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг ангилан ялгах ажилд нийтийг хамарсан ажлын хүрээнд 400 түр ажлын байр бий болгож Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас 160,0 сая төгрөгийн урамшуулал олгосон. -Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 2/149 дүгээр албан бичгээр бүх сумдын Засаг дарга нарт зориулалтын бус газарт үүссэн үүсмэл хог хаягдлыг цэвэрлэх дахин хог хаягдлын цэг үүсгэхгүй байх тал дээр чиглэл өгч, "Иргэн бүр эрсдэлгүй орчинд" аян зохион байгуулж аяны хүрээнд иргэд, байгууллагуудын Хог хаягдлын тухай хуулиар хүлээсэн эрх, үүргийг хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж ажилласан. Аяны хүрээнд 19 сумдад нийт 3642 иргэн, 239 байгууллага оролцож, 245	100

						тонн хог хаягдлыг цэвэрлэсэн. Мөн Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанаас зохион байгуулсан Орхон голын сав дагуух хур хог хаягдлын цэвэрлэгээний ажлын хүрээнд 6 ширхэг анхааруулах тэмдэг байршуулж, гарын авлага, зурагт хуудас 2500 ширхэгийг тарааж, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Хархорин сумын “Дахивар хог хаягдал бэлтгэн нийлүүлэх төв” нь хуванцар-2.8 тн, лааз-2.850 тн, шил-8740 ш-4 тн, гялгар уут 3,160 кг, хуванцар савны бөглөө 220 кг нийт 14.9 тн дахивар хог хаягдлыг төвлөрүүллээ. Хог хаягдлын цэвэрлэгээний ажилд нийт 150 иргэн, 250 хүүхэд, 21 аж ахуйн нэгж байгууллага оролцож, Орхон голын сав дагуух 3 хур хог хаягдал төвлөрсөн газрыг булж, 775 га талбайг 60 портер, 10 HINO, 1 HOWO маркын автомашинаар 190 тн хог, хаягдлыг цэвэрлэн сумдын нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлсэн байна.	
1.5.5	Гэр хорооллын айл өрхүүд болон нийтийн эзэмшлийн зам талбайд жишиг загварын хогийн сав, ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх;	-	Стандарт шаардлагын хангасан эсэх	2021 онд Онги, Дайргын гол дагуу 3 ширхэг ариун цэврийн байгууламжийг суурилуулсан.	Хогийн сав, ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлсэн байна.	-Гэр хорооллын айл өрхүүдийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг идэвхжүүлэх зорилгоор Хог хаягдлын менежментийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг “Өнгө нэм” ТББ-тай гэрээ байгуулан хог хаягдлыг ангилан ялгах, хадгалах зориулалт бүхий хогийн савны жишиг загварыг гаргаж, иргэд айл өрхүүдэд сурталчилж ажилласнаар Арвайхээр сумын 1383 өрх буюу нийт өрхийн 14,7 хувь ангилан ялгах хогийн савтай болсон. Аймгийн хэмжээнд зорилтот жилийн хүрээнд гэр хорооллын айл өрх болон албан байгууллагууд өөрсдийн санаачилгаар нүхэн жорлонгоо сайжруулж, хөрсөнд үл нэвчих 1043 ширхэг ариун цэврийн байгууламжийг шинээр байгуулсан байна. -Аймгийн хэмжээнд ангилан ялгах зориулалт бүхий 62 ширхэг хогийн савыг шинээр хийж,	100

						сумын нийтийн эзэмшлийн талбайд байршуулсан. -Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 38,0 сая төгрөгөөр 17 суултуур бүхий 3 ш зөөврийн эко ариун цэврийн байгууламж худалдан авч эвент арга хэмжээнүүдэд ашиглаж байна.	
1.5.6	Биотехникийн арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах;	5.0	Биотехникийн арга хэмжээ авсан байдал	12 сумын 65 цэгт биотехникийн арга хэмжээ авах ажлыг зохион байгуулсан.	Шаардлагатай газруудад биотехникийн арга хэмжээ авсан байна.	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар тус газраас 2022 оны 3,4,12 дугаар саруудад нэн ховор, ховор амьтдад болох аргаль, янгир, халиун буга, бор гөрөөс зэрэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах ажлыг агнуурын бүс нутагт зохион байгууллаа. Нийт 14 сумын 58 цэгт өвс, хужир тавьж, тус ажилд сумдын БОХУБайцаагч, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүд, байгаль хамгаалагчид, нөхөрлөлийн гишүүд хамтран зохион байгууллаа.	100
1.5.7	Монгол орны хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлдэг байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг зохион байгуулах.		Аймгийн хэмжээнд 25-аас доошгүй сургалт, сурталчилгааны ажил хийж, тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд тодорхой ажлуудыг зохион байгуулсан байна.	Байгалийн амьтан, ургамлын дэлхийн өдөр, Дэлхийн ой, усны өдөр, Бүх нийтээр Мод тарих үндэсний өдөр, Дэлхийн Байгаль хамгаалах өдөр	Эхний хагас жилд: 12-оос доошгүй сургалт, сурталчилгаа Жилийн эцэст: 25-аас доошгүй сургалт, сурталчилгаа	-Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд "Байгалийн амьтан, ургамлын дэлхийн өдөр"-өөр Арвайхээр сумын ерөнхий боловсролын Мэргэд, I, II, IV, V дугаар сургуулийн 8-12 ангийн сурагчдад Өвөрхангай аймгийн нэн ховор, ховор амьтан ургамлын талаар танин мэдэхүйн сургалтыг зохион байгуулж, 500 гаруй сурагчид хамрагдсан. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, зорилтот жилийн хүрээнд бүх нийтээр мод тарих өдрийн нээлтийн арга хэмжээ, тарьц суулгацны үзэсгэлэн худалдааг Арвайхээр хотод 04 сарын 29-31-ны өдрүүдэд зохион байгуулж, 11 аж ахуйн нэгж оролцож, 18 нэр төрлийн 200 гаруй мянган тарьц суулгац борлуулсан байна. "Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах" зорилтот жилийн хүрээнд ЕБ-ийн сурагчдын идэвхи санаачлагыг өрнүүлэн хүүхэд, залуучуудад эх оронч байгаль хамгаалах үзлийг төлөвшүүлэх	100

						<p>зорилгоор "Супер анги" шалгаруулах уралдааныг ГБХЗХГазар, Өвөрхангай аймаг дахь Монгол банкттай хамтран 3 үе шаттайгаар зохион байгуулж 23 сургуулийн 8000 гаруй сурагчид хамрагдсан. Эцсийн шатны шалгаруулалтыг 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Хүүхдийн ордны "Орхон" кино театрт шилдэг 10 анги хамт олны төлөөлөл болох 210 гаруй сурагчдыг хамруулан зохион байгуулж, сурагчид 7 тонн хог ангилж, 21 төрлийн шторк хийж цахим орчинд байршуулсан.</p> <p>-Тус газраас "Цоохор ирвэс хамгаалах" дэлхийн өдрийн хүрээнд сургалт танин мэдэхүйн хичээл, гарын авлага бэлтгэж Арвайхээр, Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Гучин-Ус, Уянга сумдын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, байгаль хамгаалагч нараар дамжуулан 8 сургууль, 1 цэцэрлэгийн 900 гаруй хүүхдүүдэд танин мэдэхүйн сургалт зохион байгууллаа.</p>	
<p><b>Зорилт 1.6</b> Уялдаа: АЗДҮАМХ 4.2.1.1, 4.2.1.3</p>		<p><b>Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.</b></p>					
1.6.1	Хархорин суманд "Аялал жуулчлалын гудамж байгуулах" ажил;	1.200.0 сая	Аялал жуулчлалын гудамжийг ашиглалтад оруулсан эсэх	Ажлын гүйцэтгэл 70 хувь	Хяналт тавих, хүлээх авах	<p>Аймгийн Засаг даргаас томилогдсон ажлын хэсэг Хархорин суманд хийгдэж байгаа "Аялал жуулчлалын гудамж байгуулах" ажлын гүйцэтгэлд 3 удаа хяналт тавьж ажилласан бөгөөд уг ажлын хүрээнд Хархорин, Эрдэнэзуу музейг холбосон аялал жуулчлалын гудамж байгуулах 4 багц ажил хийгдэж байна. Одоогийн байдлаар "Цэвэр ус, ариутгах татуургын шугам сүлжээ, бохирын цооног" хийх багц ажлын хүрээнд 520 метр цэвэр усны шугам, 480 метр бохир усны шугам татах ажил, "Гадна цахилгаан хангамж, гэрэлтүүлэг" багц ажлаас 1500 метр агаарын шугам татаж, 04 кв-ийн дэд станцыг байршуулах, "Явган зам, гадна хайс, сүүдрэвч" багцын хүрээнд 1100 метр хайсан хашаа, явган замын газар</p>	70

						шорооны ажил тус тус хийгдээд байна. “Авто зогсоол, эко хавтан” багц ажлын хүрээнд 28700 м2 хатуу хучилттай авто зогсоол, 3580 м2 эко хавтан зам баригдсан.	
1.6.2	“Ай Ти Эм” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох;	10.0	Үзэсгэлэнд оролцсон эсэх	2021 онд 18 аж ахуй нэгж оролцсон.	Үзэсгэлэнд оролцох ААНэгж, байгууллагуудыг зохион байгуулалтаар хангаж оролцсон байна.	-“Ай Ти Эм-2022” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд 40 аж ахуй нэгж, байгууллага оролцож, өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж, 2023 онд хамтран ажиллах гэрээ хэлэлцээрүүд хийгдсэн. Уг үзэсгэлэн худалдааны үеэр “Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын зочлох үйлчилгээний чанарыг сайжруулах нь” сэдэвт аймгийн зөвлөгөөнийг 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулж, аймгийн хэмжээнд аялал жуулчлал эрхлэгчдийн төлөөлөл 42 хүн оролцлоо.	100
1.6.3	Аялал жуулчлалын гол маршрутын дагуу ариун цэврийн байгууламжийг тоог нэмэгдүүлэх;	38.5	Дотоод, гадаад жуулчдын ая тухтай аялах боломж бүрдсэн байна.	2021 онд 3 ариун цэврийн байгууламж байршуулсан.	5-аас доошгүй ариун цэврийн байгууламжийг байршуулсан байна.	-Аялал жуулчлалын гол маршрут дагуу эко ариун цэврийн байгууламжийг байгуулах зорилтын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 17 суултуур бүхий 3 ш зөөврийн эко ариун цэврийн байгууламж худалдан авсан. Уг ажилд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 38,5 төгрөг зарцуулсан.	100
1.6.4	“Торгоны зам-Хархорум хот”, “Монгол эсгий урлалын баяр”, “Сарлагын баяр”, “KHARAKHORUM ICE FISTIVAL” эвентүүдийг зохион байгуулах;	60.0	Эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байх	2019 оны байдлаар 4500 жуулчид зорин ирж үзсэн.	Эвент арга хэмжээг зорин ирж үзэх жуулчдын тоо нэмэгдсэн байна.	-Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хужирт, Бат-Өлзий сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн “Дэлхийн өв-Орхон голын нүүдэлчид” аялал жуулчлалын холбоо хамтран бүс нутгийн онцлогт тулгуурласан аялал жуулчлалын эвент арга хэмжээ “МОНГОЛ ЭСГИЙ УРЛАЛЫН БАЯР”-ыг Хужирт суманд 7 сарын 22-ны өдөр, “САРЛАГИЙН БАЯР”-ыг Бат-Өлзий суманд 2022 оны 07 сарын 23-ны өдөр тус тус зохион байгууллаа. Эвент арга хэмжээнүүдийг үзэж сонирхохоор Франц, Польш, Герман, Япон, Швейцар зэрэг орны жуулчид, дотоодын	70

						аялагчид нийт 1000 гаруй жуулчид үзэж сонирхлоо. БОАЖЯам Солонгос улстай аялал жуулчлалын чиглэлээр хамтран ажиллах хүрээнд Солонгосын үндэсний EBS телевизийн “Дэлхийгээр аялцгаая” нэвтрүүлгийн багийнхан манай аймагт дээрх эвентүүдийн үеэр ирж 2 удаагийн нэвтрүүлгийг бэлтгэн Солонгос улсад аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ сурталчилсан. “KHARAKHORUM ICE FESTIVAL” эвентийн бэлтгэл ажил хийгдэж байна.	
1.6.5	Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалтыг зохион байгуулах.	15.0	Аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлж байгаа иргэд, аж ахуй нэгжийн үйлчилгээний чанар стандарт сайжирсан байна.	2021 онд 60 иргэн зочлох үйлчилгээний сургалтанд хамрагдсан.	250-аас доошгүй иргэд сургалтанд хамрагдсан байна.	-Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалтыг орон нутгийн нөөц боломжид тулгуурлан зохион байгуулахаар төлөвлөж, аймгийн Политехникийн коллежтой хамтран аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа нутгийн иргэдийг чадавхжуулах сургалтыг Бат-Өлзий суманд зохион байгуулж, зочид буудлын үйлчилгээний ажилтны ангид 28 иргэн, аяллын хөтөчийн ангид 25 иргэн тус тус хамрагдлаа. -Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа үйлчилгээний байгууллагуудын чанар стандартыг сайжруулах зорилгоор тохирлын үнэлгээ хийх аймгийн ажлын хэсэг 2022 оны 6 сарын 30-наас 7 сарын 06-ныг дуусталх хугацаанд гэст хаус /гэр буудал/, жуулчны баазуудад тохирлын үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгсөн.	100
<b>Зорилт 1.7</b> <b>Уялдаа: АЗДҮАМХ</b> 2.3.3.1, 2.3.3.2		<b>Газар, газрын хэвлий түүний баялгийг хамгаалах зүй зохистой ашиглах, уул уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулах, нийгмийн хариуцлагын гэрээг хэрэгжүүлж ажиллах</b>					
1.7.1		-	Хамтран хяналт шалгалт хийсэн тоо, арга хэмжээ авч	3 удаа хамтарсан хяналт шалгалт хийгдсэн	Хамтарсан хяналт шалгалтыг 3-аас доошгүй удаа зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг	-Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн 09/241 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хамт 07 сарын 4-6-ны өдрүүдэд Уянга сумын нутагт ашигт малтмал	100

	Газар, газрын хэвлий түүний баялгийг хамгаалах зүй зохистой ашиглах, уул уурхайн нөхөн сэргээлтийн талаар УИХ, Засгийн газар, аймгийн Засаг даргаас дэвшүүлсэн бодлого, хөтөлбөр, шийдвэрийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;		хэрэгжүүлсэн байдал		хангуулан ажиллана.	ашиглалтын үйл ажиллагаа явуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд шалгалт хийж ажилласан. Шалгалтын үеэр “Баярсголд” ХХК-ийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, ТЭЗҮ-ийн хугацаа дууссан ч нэмэлт тодотгол хийлгээгүй үйл ажиллагаа явуулсан зөрчил илэрсэн тул Уянга сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч угаах 2 төхөөрөмжийг лацдан үйл ажиллагааг зогсоон, зөрчлийн тухай хуулийн арга хэмжээ авч ажилласан. Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Онги-Таац голын сав газрын захиргааны даргын баталсан удирдамжийн дагуу ажлыг хэсэг 09 дүгээр сарын 2-нд Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын Өртөнт хэмээх газар үйл ажиллагаа явуулсан иргэний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж ажилласан. Тухайн иргэн нь ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж, байгаль орчинд хохирол учруулсан үйлдэл нь гэмт хэргийн хэргийн шинжтэй байсан тул харьяаллын дагуу аймгийн Цагдаагийн газарт шалгуулахаар холбогдох материалыг хүргүүлсэн. Мөн аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг хуулийн хэрэгжилтийг хангуулах, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор 9 сард уул уурхайн болон автозамын завсар шинэчлэлийн ажил гүйцэтгэж байгаа буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, холбогдох чиглэлийг өгч, хэрэгжилтийг хангуулсан.	
1.7.2	Уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн нөхөн сэргээлтийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, БОМТөлөвлөгөөний	-	Нөхөн сэргээлтийг төлөвлөгөөний дагуу бүрэн хийлгүүлж	2021 онд 95 га талбайд нөхөн сэргээлт хийлгэсэн	Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангуулан ажилласан байна.	-Ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Баярсголд” ХХК, “Өгөөмөр-Өргөө” ХХК, “АУМ-Алт” ХХК-иуд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг тухайн жилийн батлагдсан уулын ажлын	90

	биелэлтийг хүлээн авч, дүгнэлт гаргах;		хүлээн авсан байх			төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заагдсан хэмжээгээр хийж гүйцэтгэсэн. Үүнд дээрх аж ахуйн нэгжүүд 2022 онд техникийн нөхөн сэргээлтийг 55.5 га, биологийн нөхөн сэргээлтийг 10.5 га талбайд буюу нийт 66 га талбайд хийж аймаг, сумын ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.	
1.7.3	“Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах.	-	Төлөвлөгөө боловсруулж батлуулж, хэрэгжилтийг хангасан эсэх	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	-Ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Баярсголд”ХХК, “Өгөөмөр-Өргөө”ХХК, “АУМ-Алт”ХХК-иуд 2021 онд техникийн нөхөн сэргээлтийг 67.49 га, биологийн нөхөн сэргээлтийг 7 га талбайд, 2022 онд техникийн нөхөн сэргээлтийг 55.5 га, биологийн нөхөн сэргээлтийг 10.5 га талбайд, бичил уурхайн нөхөрлөлүүд техникийн нөхөн сэргээлтийг 15 га талбайд буюу нийт 155.49 га талбайд хийж аймаг, сумын ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн. -Шүүхийн шийдвэрийн дагуу хууль бус үйл ажиллагаа явуулсан иргэдээс төвлөрүүлсэн байгаль орчинд учруулсан хохирол, нөхөн сэргээлтийн зардлаар Уянга сумын Бөөрөлжүүтийн голд нөхөн сэргээлт хийх сонгон шалгаруулалтад “АУМ-Алт” ХХК шалгарч нөхөн сэргээлт хийх гэрээ байгуулсан гэрээний дагуу 2021 онд 9.2 га талбайд нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлийг гүйцэтгэсэн. Мөн бусад хууль бусаар үйл ажиллагаа явуулж, байгаль орчинд учруулсан хохирол, нөхөн сэргээлтийн зардал төлөхөөр болсон иргэдээс авах төлбөрийг барагдуулж, нөхөн сэргээлт хийлгэхээр аймгийн Прокурорын газартай хамтран ажиллаж байна. -Гар аргаар ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж нөхөн сэргээгдээгүй орхигдсон 81.29 га газрыг нөхөн сэргээх зорилгоор бичил уурхайн зориулалтаар аймгийн ИТХурлын 2022 оны 04	90



						сарын 12-ны өдрийн 10/06 дугаар тогтоолоор тусгай хэрэгцээнд аваад байна.	
<b>ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ</b>							
<b>Зорилт 2.1</b>		<b>Байгууллагын дотоод хяналт, архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг хэрэгжүүлэх</b>					
2.1.1	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт зохион байгуулах;	-	Дотоод хяналтын чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ, чанар, үр дүн	2 удаа зохион байгуулсан	Дотоод хяналтын нэгжийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн байна.	-Тус газрын дотоод хяналтын нэгжийн 2022 оны төлөвлөгөөг боловсруулж, газрын даргаар батлуулсан. Төлөвлөгөөнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлын явцын тайланг гаргаж Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэст хүргүүлсэн. -Аймгийн Засаг даргын 2021 оны А/337 дугаар захирамжаар байгуулагдсан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ажлыг хүлээн авах ажлын хэсэгт дотоод хяналтын нэгжийн төлөөллийг оролцуулж, хяналт тавьж ажилласан.	100
2.1.2	Байгууллагын дотоод журмыг шинэчлэн батлах;	-	Холбогдох хуульд тогтоомжид нийцүүлж боловсруулсан эсэх	2018 онд шинэчилсэн.	Дотоод журмыг шинэчилсэн байх	-Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан байгууллагын дотоод журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж хамт олноор хэлэлцүүлж газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар баталсан.	100
2.1.3	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилийг хангах;	-	Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгээр	2021 оны төлөвлөгөө 98,4 хувьтай хэрэгжсэн.	Байгууллагын төлөвлөгөөг боловсруулж батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан байх;	-Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах арга хэмжээний саналыг мэргэжилтүүдээс авч нэгтгэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан аргачлал, зааврын дагуу нэгтгэж боловсруулан газрын даргаар хянуулж, аймгийн Засаг даргаар батлуулсан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 52 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллалаа.	100
2.1.4	Тухайн жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн	-	Чанар, үр дүн, хэрэгжилтийн хувь, хугацаа	Тогтоосон хугацаанд тайлагнасан.	Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу	-Тухайн жилийн хяналт, шинжилгээ-үнэлгээний тайланг дараа оны эхний улиралд тайлагнадаг бөгөөд 2021 оны тайланг ЗГ-ын	100

	тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэж, түүний мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж биелэлтийг хангах;				тайланг нэгтгэж биелэлт, үр дүнг тооцон холбогдох газарт тайлагнасан байх;	2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу нэгтгэн хяналт үнэлгээ хийж, тогтоосон хугацаанд ЗДТГ-т тайлагнасан. -Аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний хэлтсээс ирүүлсэн зөвлөмжийг хангах хүрээнд байгууллагын үйл ажиллагааг иргэд олон нийтэд ил тод, нээлттэй байлгах нөхцлийг бүрдүүлж <a href="http://nature.ov.gov.mn">nature.ov.gov.mn</a> байгууллагын албан ёсны вэйб сайтыг шинээр хийлгүүлж, мэдээ мэдээллийг шинэчлэн ил тод байдлыг ханган ажиллалаа. Вэйб сайтыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, уг сайтыг хариуцан ажиллах мэргэжилтэнг сургалтад хамруулж, сайт хийлгэх зардлыг байгууллагын төсвийн боломжид тулгуурлан шийдвэрлэлээ. Мөн зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулж газрын даргаар батлуулан мэргэжилтнүүдэд танилцуулж хэрэгжилтийг ханган ажилласан.	
2.1.5	Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;	-	Архив, албан хэргийг холбогдох хууль, журам, заавар, стандартын дагуу хөтөлсөн байна.	Архив албан хэрэг хөтлөлтийг заавар стандартын дагуу хөтлөн явуулсан.	-Албан хаагчдад сургалт зохион байгуулах -заавар стандартыг мөрдөж ажиллах	-“Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай” хууль, ЗГ-ын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Стандарт хэмжил зүйн газрын даргын 2021 оны с/30 дугаар тушаалаар батлагдсан MNS 5140-2:2021 стандарт, ЗГ-ын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-уудыг цахим сайтуудаас татаж авч гарын авлага болгон ашиглаж байна. -Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг Архив-бичиг хэргийн ажилтантай хамтран боловсруулж газрын даргаар батлууллаа.	100

2.1.6	Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн журам, Архивын ажлын дүрмийг шинэчлэн батлах;	-	Холбогдох хууль, тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн боловсруулсан эсэх	-	Дүрэм, журмыг шинэчилж мөрдөж эхэлсэн байна.	-Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль шинээр батлагдаж, Архив албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, стандарт шинэчлэгдсэнтэй холбогдуулан байгууллагын Архив-албан хэрэг хөтлөлтийн журам, Архивын ажлын дүрмийг шинэчлэн боловсруулж газрын даргын 2022 оны А/02 тушаалаар баталлаа.	100
2.1.7	Архив-албан хэрэг хөтлөлтийн талаар албан хаагчдад сургалт зохион байгуулах.		Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	1 удаа зохион байгуулсан.	Шинээр гарсан хууль, дүрэм журмыг танилцуулах	Тус газрын Архив-бичиг хэргийн ажилтныг аймгийн Архивын тасгаас зохион байгуулсан “Архив албан хэрэг хөтлөлт”-ийн сургалт, Архивын Ерөнхий газраас зохион байгуулсан “Монгол бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих бэлтгэл ажлыг хангах” талаарх сургалтад тус тус хамруулсан. Албан хаагчдад зориулсан сургалтыг 2 удаа цахим хэлбэрээр зохион байгуулж сумдын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүд, байгаль хамгаалагчид, Сум дундын Ойн ангийн албан хаагчид оролцсон.	100
<b>ГУРАВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ</b>							
<b>Зорилт 3.1</b>		<b>Байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгжид холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ил тод, чирэгдэлгүй, түргэн шуурхай, хүртээмжтэй болгох</b>					
3.1.1	Иргэдээс ирсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэх;	-	-Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүртгэж эзэнжүүлэн шийдвэрлэлтэд хяналт тавьж, хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна. -Өргөдөл гомдлын мэдээг холбогдох дээд байгуулагад	2021 онд газрын хэмжээнд 44 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирж хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.	Хуулийн хугацаанд шийдвэрлэж, мэдээ тайланг холбогдох байгууллагад тайлагнасан байна.	2022 оны 11 сарын байдлаар газрын хэмжээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 35 өргөдөл, гомдол ирснийг хүлээн авч бүртгэн холбогдох албан тушаалтанд газрын даргын цохолтоор хүлээлгэн өгч, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Өргөдөл гомдлын мэдээг холбогдох байгууллагад улирал бүр гарган тайлагнасан. Мөн байгууллагын вэйб сайтад өргөдөл гомдлын талаарх мэдээ мэдээлийг байршуулж ил тод байдлыг хангасан.	100

			ТОГТООСОН хугацаанд хүргүүлсэн байх				
3.1.2	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ ус, рашаан ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, ой, ан амьтны экологи эдийн засгийн үнэлгээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гаргах.	-	Гаргасан үнэлгээ, дүгнэлт, зөвшөөрлийг хууль тогтоомжийн хүрээнд гаргасан байх	2021 онд иргэн аж ахуйн нэгжээс ирүүлсэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ 43, ус рашаан ашиглуулах зөвшөөрөл 7, цооног өрөмдөж гүн өрмийн худаг гаргах зөвшөөрөл 13, ан амьтны экологи эдийн засгийн үнэлгээ 17, ойд учруулсан экологи эдийн засгийн үнэлгээ-9 гарсан.	Иргэдэд үзүүлж буй үйлчилгээг хууль тогтоомжийн хүрээнд чирэгдэлгүй, хурдан шуурхай хүргэсэн байх.	-Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, шат дамжлагыг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх хүрээнд тус газраас иргэдэд үзүүлдэг ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гүн өрмийн худаг гаргах зөвшөөрөл, усны мэргэжлийн байгууллагын эрх олгох дүгнэлт, аймгийн Засаг даргын тодорхойлолт зэрэг 5 төрлийн үйлчилгээг цахимжуулж, "E-MONGOLIA" СИСТЕМД-д шилжүүлсэн. 2022 оны 12 сарын 01-ний байдлаар ус ашиглуулах талаар 10 аж ахуйн нэгж, байгууллагад дүгнэлт гаргаж, ус, рашаан ашиглуулах талаар 9 аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж, байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт 28, ойн экологи эдийн засгийн үнэлгээ 15, мэргэжлийн байгууллагын дүгнэлт 2-г тус тус гаргасан байна. -Зэрлэг гахай тээвэрлэсэн гэх 11000428 дугаартай гомдол мэдээлэлд, эрхийн бичиг, зөвшөөрөлгүйгээр тарваганы мах худалдан авсан гэх 2226000124, 2226000117, 2226000118, 2226000119 2226000124, цоохор ирвэс хууль бусаар агнасан гэх 11001206 дугаартай зөрчлүүдэд аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газрын ирүүлсэн материалыг дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн.	100
Дундаж үнэлгээ							96,7

ТӨЛӨВЛӨГӨӨ ХЯНАСАН:

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

ЗАСАГ ДАРГА  
ТӨЛӨВЛӨГӨӨ ТАЙЛАГНАСАН:

А.ИШДОРЖ  
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА

Г.БАЯСГАЛАН